



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/295

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын 10 хоногийг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Дархлаажуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2017 оны 10 дугаар сарын 16-наас 26-ны өдрүүдэд "Томуугийн эсрэг дархлаажуулалт" уриан дор зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арав хоногийн хугацаанд дараах арга хэмжээг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай. Үүнд:

2.1. Америкийн Нэгдсэн Улсын "Протейн Сайнс", Австрали Улсын "Секирюс", Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Хуалан биоложикс" үйлдвэрийн томуугийн эсрэг вакцинаар эрүүл мэндийн ажилтан, нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нар болон архаг, суурь өвчтэй хүн, өндөр настан, жирэмсэн эмэгтэй, нийслэлийн дүүргүүдийн сонгогдсон цэцэрлэгийн хүүхэд зэрэг зорилтот бүлгийн хүн амыг тархвар судлалын заалтаар дархлаажуулах;

2.2. Улсын хэмжээнд улаанбурхан өвчний эсрэг вакцинаар 15 настай хүүхдийг дархлаажуулах;

2.3. Заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон 15 хүртлэх насны хүүхдийг нөхөн дархлаажуулах.

3. Томуугийн эсрэг вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг нэгдүгээр, Хамралтыг мэдээлэх хуудсыг хоёрдугаар, Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг тандах хуудсыг гуравдугаар, Улаанбурханы эсрэг вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4. Томуугийн эсрэг вакцины үйлдвэрлэгчээс ирүүлсэн зааврыг эрүүл мэндийн байгууллагуудад цаг тухайд нь хүргүүлж, зааврын дагуу дархлаажуулах арга хэмжээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д даалгасугай.